

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 05 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 05 дугаар сарын биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын 38 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Нийт арга хэмжээний 81.6 хувь нь үр дүнтэй буюу 100, 10.5 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 90, 5.3 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай буюу 70, 2.6 хувь нь үр дүнгүй буюу 0 хувьтай тус тус үнэлэгдсэн байна. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Хувь
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай			Үр дүнгүй	Дундаж хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	
1	2	3	4	5	6	7	8
38	31	4	2	-	-	1	94.7

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд “Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ” арга хэмжээнд тусгагдсан ажлууд 100, Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” арга хэмжээнд тусгагдсан ажлууд 95.7, “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” арга хэмжээнд тусгагдсан ажлууд 94.1, Бодлогын баримт бичигт

тусгагдсан зорилтын хүрээнд “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна” арга хэмжээнд тусгагдсан ажлууд 90 хувиар үнэлэгдсэн. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	0-30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна	1	-	1	-	-	-	90
2	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	7	4	3	-	-	-	95.7
3	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	27	24	-	2	-	1	94.1
4	Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ	3	3	-	-	-	-	100
Нийт		38	31	4	2	-	1	94.7

Зохион байгуулалтын нэгж тус бүрээр ангилан авч үзвэл (Хүснэгт 3):

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	0%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Захиргаа, удирдлагын газар	14	13	-	-	-	1	92.8
2	Виз, зөвшөөрлийн газар	2	-	2	-	-	-	90
3	Иргэний харьяаллын газар	1	1	-	-	-	-	100
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	3	-	-	-	-	100
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	4	3	-	1	-	-	92.5
6	Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	4	3	-	1	-	-	92.5
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	2	2	-	-	-	-	100
8	Мэдээллийн технологийн хэлтэс	4	3	1	-	-	-	97.5
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	1	-	1	-	-	-	90
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	2	2	-	-	-	-	100
11	Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
Нийт		38	31	4	2	-	1	94.7

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2024 оны 05 дугаар сард төлөвлөн гүйцэтгэсэн 38 арга хэмжээний хэрэгжилт 94.7 хувьтай үнэлэгдлээ. Цаашид дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:

1. “Үр дүнгүй” буюу 0 хувьтай үнэлэгдсэн “Байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр төрийн үйлчилгээний зарим албан тушаал, төрийн тусгай албан тушаалын ангилал зэрэглэлд шилжсэнтэй холбогдуулан албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх” арга хэмжээ (18):

- Төрийн албаны зөвлөлөөс албан тушаалын тодорхойлолтын батлах зөвшөөрөл ирүүлсний дараа албан тушаалын тусгай шалгалтын захиалга хүргүүлэх арга хэмжээг авах;

2. “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 70 хувьтай үнэлэгдсэн “Албан хаагчдыг гадаад сургалтад хамруулах бэлтгэл ажлыг хангах” арга хэмжээ (11):

- БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хотод зохион байгуулагдах “Хилийн болон иргэний харьяаллын мэргэжлийн сургалт”-д хамрагдах албан хаагчдын бэлтгэл ажлыг хангах;

“Виз, зөвшөөрлийн газрын албан хаагчдын хувцас солих өрөөнд урсгал засвар хийж, 301 болон 308 тоот өрөөний шалыг солих” арга хэмжээ (35):

- 301 тоот өрөөний шалыг солих ажлыг гүйцэтгэж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх;

3. “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90-100 хувьтай үнэлэгдсэн 35 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.